



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

БАЯНХОНГОР СУМЫН 5 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аудитын код: БНА-2021/61/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор хот

2021 он

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд Тэргүүлэх аудитор Б.Мөнхбат

Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер А.Цээням:

Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn


Ахлах аудитор Б.Должмаа

Утас: 88110538 Цахим хаяг: doljmaab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Төрийн аудитын санал дүгнэлт /эх хувь/	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	11
3.Аудитын тайлан	11
3.1. Ерөнхий зүйл	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт.....	12
3.4. Материаллаг байдал	13
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	14
3.7. Шилэн дансны мэдээлэл	16
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.9. Аудитын илрүүлэлт	16
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	16
Аудитын зөвлөмж	17
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	17
4. Менежментийн захидал.....	18
5. Хавсралт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	20



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БСШУЯ	Боловсрол, соёл шинжлэх ухааны яам



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

Г БАЯНХОНГОР СУМЫН 5 ДУГААР Т
ЦЭЦЭРЛЭГИЙН ТӨСВИЙН
ЗАХИРАГЧ Б.ИШМАА ТАНАА

2021.02.25 № 2/159

танай _____ -ны № _____ -т

Г АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ Г

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны Баянхонгор сумын 5 дугаар цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор сумын 5 дугаар цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын дарга нь Сумын Засаг дарга, аймгийн Боловсрол, соёл урлагийн газартай гэрээ байгуулж гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулан биелэлтийг тооцон ажилласан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

2021 А4 ТООТ

005020139

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Төгсгөөр/ Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	63,620,405.16	46,894,997.56
33	АВЛАГА	2,359,500.00	00.00
335	Бусад авлага	2,359,500.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	2,359,500.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	61,260,905.16	46,894,997.56
351	Түүхий эд материал	29,867,043.16	20,426,639.16
35110	Тусгай зориулалттай материал	29,867,043.16	17,284,639.16
35130	Эм боох материал	00.00	3,142,000.00
354	Хангамжийн материал	31,393,862.00	26,468,358.40
35410	Бичиг хэргийн материал	00.00	477,750.00
35420	Аж ахуйн материал	8,677,969.00	7,841,700.40
35460	Хүнсний материал	4,355,250.00	00.00
35470	Бусад хангамжийн материал	18,360,643.00	18,148,908.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	733,764,648.22	1,272,209,225.87
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	733,764,648.22	1,272,209,225.87
392	Биет хөрөнгө	584,314,648.22	1,122,759,225.87
39201	Барилга, байгууламж, орон сууц	637,800,131.00	1,189,567,657.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-84,418,275.96	-124,335,270.21
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	52,177,797.00	80,520,727.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-39,990,165.64	-46,891,825.10
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	23,466,996.28	33,502,996.28
39208	Хуримтлагдсан элэгдэл	-14,337,596.63	-17,514,305.11
39214	Бусад үндсэн хөрөнгө	20,092,024.15	20,092,024.15
39215	Хуримтлагдсан элэгдэл	-10,476,261.98	-12,182,778.14
393	Биет бус хөрөнгө	149,450,000.00	149,450,000.00
39301	Програм хангамж	919,720.00	919,720.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-919,720.00	-919,720.00
39303	Бусад биет бус хөрөнгө	149,450,000.00	149,450,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	797,385,053.38	1,319,104,223.43
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	20,538.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	20,538.00
413	Өглөг	00.00	20,538.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	20,538.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	797,385,053.38	1,319,083,685.43
51	Засгийн газрын хувь оролцоо	797,385,053.38	1,319,083,685.43
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	457,736,119.00	457,736,119.00
51101	Өмч: - төрийн	457,736,119.00	457,736,119.00
512	Хуримтлагдсан үр дүн	-176,654,919.45	345,043,712.60
51210	Өмнөх үеийн үр дүн	-176,654,919.45	-176,654,919.45
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	521,698,632.05
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	516,303,853.83	516,303,853.83
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	797,385,053.38	1,319,104,223.43

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /Төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	535,798,000.00	1,149,930,174.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,770,200.00	546,654,974.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,770,200.00	546,654,974.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,700,000.00	546,654,974.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	397,968.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,700,000.00	546,257,006.00
120009	Бусад орлого	70,200.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	532,027,800.00	603,275,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	432,021,900.00	501,321,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	432,021,900.00	501,321,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,979,800.00	4,923,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,979,800.00	4,923,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	93,026,100.00	97,030,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	93,026,100.00	97,030,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	634,582,996.75	628,231,541.95
21	УРСГАЛ ЗАРДАЛ	634,582,996.75	628,231,541.95
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	627,529,353.75	617,403,362.95
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	305,314,258.00	351,719,932.53
210101	Үндсэн цалин	256,670,758.00	272,398,345.53
210102	Нэмэгдэл	25,834,600.00	55,917,596.00
210104	Урамшуулал	22,808,900.00	23,403,991.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,812,925.00	42,782,989.47
210201	Тэтгэврийн даатгал	27,476,145.00	29,020,348.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,112,833.00	3,765,840.13
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,670,668.00	3,234,702.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,732,489.00	1,086,574.19
210205	Эрүүл мэндийн даатгал	3,820,790.00	5,675,525.15
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	89,920,338.00	95,656,655.00
210301	Гэрэл, цахилгаан	8,587,409.00	7,311,169.00
210302	Түлш, халаалт	63,543,039.00	75,152,100.00
210303	Цэвэр, бохир ус	11,835,896.00	13,193,386.00
210304	Байрны түрээс	5,953,994.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,350,899.84	26,406,107.60
210401	Бичиг хэрэг	278,010.00	220,300.00
210402	Тээвэр, шатахуун	590,000.00	1,400,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,347,324.00	1,450,400.00
210404	Ном, хэвлэл	97,000.00	67,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	205,000.00	910,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,365,200.00	1,846,500.00
210408	Бараа материал акталсны зардал	12,468,365.84	20,511,907.60
2105	Нормативт зардал	73,215,000.00	41,453,500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	31,950.00	1,750,400.00
210502	Хоол, хүнс	73,005,900.00	39,508,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	177,150.00	195,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,856,700.00	3,064,084.00
210604	Урсгал засвар	3,856,700.00	3,064,084.00
2107	Томилолт, зочны зардал	182,700.00	64,000.00
210702	Дотоод албан томилолт	182,700.00	64,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,147,000.00	700,500.00

**Баянхонгор сумын 5 дугаар Цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	897,000.00	400,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	300,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	97,729,532.91	55,555,594.35
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	284,200.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,746,740.00	3,853,716.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	95,698,592.91	51,701,878.35
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,053,643.00	10,828,179.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,028,600.00	5,119,600.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	6,979,800.00	4,923,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	48,800.00	195,800.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	673,645.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	673,645.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	25,043.00	5,034,934.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	25,043.00	5,034,934.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-98,784,996.75	521,698,632.05
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	146,016.87	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	146,016.87	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-146,016.87	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-98,931,013.62	521,698,632.05

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /Төгрөгөөр/
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	537,476,705.00	603,275,200.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	70,200.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	70,200.00	00.00
120009	Бусад орлого	70,200.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	537,406,505.00	603,275,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	501,321,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	432,021,900.00	501,321,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,979,800.00	4,923,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,979,800.00	4,923,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	93,026,100.00	97,030,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	93,026,100.00	97,030,300.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	5,378,705.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	5,378,705.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	535,976,705.00	558,560,750.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	535,976,705.00	558,560,750.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	523,397,357.00	547,732,571.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	305,541,483.00	349,816,116.00
210101	Үндсэн цалин	256,897,983.00	272,377,807.00
210102	Нэмэгдэл	25,834,600.00	54,034,318.00
210104	Урамшуулал	22,808,900.00	23,403,991.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,621,700.00	44,268,300.00
210201	Тэтгэврийн даатгал	26,988,300.00	30,102,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,908,300.00	3,541,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,326,700.00	2,833,200.00

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

**Баянхонгор сумын 5 дугаар Цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210204	Ажилгүйдлийн даатгал	581,600.00	708,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,816,800.00	7,083,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	90,226,100.00	95,356,655.00
210301	Гэрэл, цахилгаан	8,593,171.00	7,311,169.00
210302	Түлш, халаалт	63,843,039.00	74,852,100.00
210303	Цэвэр, бохир ус	11,835,896.00	13,193,386.00
210304	Байрны түрээс	5,953,994.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,798,574.00	6,429,800.00
210401	Бичиг хэрэг	279,050.00	176,200.00
210402	Тээвэр, шатахуун	590,000.00	1,400,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,347,324.00	1,450,400.00
210404	Ном, хэвлэл	97,000.00	97,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	180,000.00	1,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,305,200.00	2,305,300.00
2105	Нормативт зардал	74,631,400.00	40,391,950.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	91,950.00	4,591,400.00
210502	Хоол, хүнс	73,662,300.00	35,102,850.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	877,150.00	697,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,500,200.00	3,300,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	6,500,200.00	2,300,200.00
2107	Томилолт, зочны зардал	182,700.00	64,000.00
210702	Дотоод албан томилолт	182,700.00	64,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,143,800.00	1,043,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	943,800.00	743,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000.00	300,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,751,400.00	7,061,750.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	70,200.00	106,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,681,200.00	6,955,750.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,579,348.00	10,828,179.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,554,305.00	5,119,600.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	5,378,705.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	6,979,800.00	4,923,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	195,800.00	195,800.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	673,645.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	673,645.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	25,043.00	5,034,934.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	25,043.00	5,034,934.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	1,500,000.00	44,714,450.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-1,500,000.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,500,000.00	44,714,450.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,500,000.00	44,714,450.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,500,000.00	44,714,450.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,500,000.00	44,714,450.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-1,500,000.00	-44,714,450.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /					
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	308,286,119.00	00.00	62,070,425.59	370,356,544.59
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	308,286,119.00	00.00	62,070,425.59	370,356,544.59
C07	Тайлант үеийн үр дүн	149,450,000.00	00.00	-140,742,731.42	8,707,268.58
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	457,736,119.00	516,303,853.83	-176,654,919.45	797,385,053.38
D01	2020 оны 01-р сарын 31-нээрх үлдэгдэл	457,736,119.00	516,303,853.83	-176,654,919.45	797,385,053.38
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	457,736,119.00	516,303,853.83	-176,654,919.45	797,385,053.38
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	521,698,632.05	521,698,632.05
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	457,736,119.00	516,303,853.83	345,043,712.60	1,319,083,685.43

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /					
Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	598,351,400.00	592,642,821.00	-5,708,579.00	99.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	598,351,400.00	592,642,821.00	-5,708,579.00	99.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	598,155,600.00	592,447,021.00	-5,708,579.00	99.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	354,146,400.00	349,816,116.00	-4,330,284.00	98.8
210101	Үндсэн цалин	273,043,200.00	272,377,807.00	-665,393.00	99.8
210102	Нэмэгдэл	54,469,600.00	54,034,318.00	-435,282.00	99.2
210104	Урамшуулал	24,633,600.00	23,403,991.00	-1,229,609.00	95.0
210105	Гэрээт ажлын хөлс	2,000,000.00	00.00	-2,000,000.00	0.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,268,300.00	44,268,300.00	0.00	100.0
210201	Тэтгэврийн даатгал	30,102,400.00	30,102,400.00	0.00	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	3,541,400.00	3,541,400.00	0.00	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,833,200.00	2,833,200.00	0.00	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	708,300.00	708,300.00	0.00	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	7,083,000.00	7,083,000.00	0.00	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	96,030,300.00	95,356,655.00	-673,645.00	99.3
210301	Гэрэл, цахилгаан	7,698,500.00	7,311,169.00	-387,331.00	95.0
210302	Түлш, халаалт	74,749,800.00	74,852,100.00	102,300.00	100.1
210303	Цэвэр, бохир ус	13,582,000.00	13,193,386.00	-388,614.00	97.1
2104	Хангамж, бараа материалын зардал	6,429,800.00	6,429,800.00	0.00	100.0
210401	Бичиг хэрэг	176,200.00	176,200.00	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	1,400,000.00	1,400,000.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,450,400.00	1,450,400.00	0.00	100.0
210404	Ном, хэвлэл	97,900.00	97,900.00	0.00	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,305,300.00	2,305,300.00	0.00	100.0

**Баянхонгор сумын 5 дугаар Цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

2105	Нормативт зардал	44,892,000.00	44,891,950.00	-50.00	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,591,400.00	4,591,400.00	0.00	100.0
210502	Хоол, хүнс	35,102,900.00	35,102,850.00	-50.00	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,197,700.00	5,197,700.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	28,886,100.00	28,300,200.00	-585,900.00	98.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,585,900.00	1,000,000.00	-585,900.00	63.1
210604	Урсгал засвар	27,300,200.00	27,300,200.00	0.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	182,700.00	64,000.00	-118,700.00	35.0
210702	Дотоод албан томилолт	182,700.00	64,000.00	-118,700.00	35.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,043,800.00	1,043,800.00	0.00	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	743,800.00	743,800.00	0.00	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	300,000.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22276200.00	22276200.00	0.00	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,000,000.00	8,000,000.00	0.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,276,200.00	14,276,200.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	195800.00	195800.00	0.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	195,800.00	195,800.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	195,800.00	195,800.00	0.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	598,351,400.00	592,642,821.00	-5,708,579.00	99.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	501,321,100.00	496,286,166.00	-5,034,934.00	99.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	501,321,100.00	496,286,166.00	-5,034,934.00	99.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	501,321,100.00	496,286,166.00	-5,034,934.00	99.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	97,030,300.00	96,356,655.00	-673,645.00	99.3
132001	Орон нутгийн төсвөөс	97,030,300.00	96,356,655.00	-673,645.00	99.3
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	01.00	01.00	0.00	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	32.00	32.00	0.00	100.0
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	25.00	25.00	0.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	06.00	06.00	0.00	100.0
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	260.00	260.00	0.00	100.0
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	260.00	260.00	0.00	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	32.00	32.00	0.00	100.0
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	17.00	17.00	0.00	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	15.00	15.00	0.00	100.0

005	ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИНГҮЙ САНАА ДҮГНЭЛТ
------------	--

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	4,923,800.00	4,923,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	4,923,800.00	4,923,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	4,923,800.00	4,923,800.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	4,923,800.00	4,923,800.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	4,923,800.00	4,923,800.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	4,923,800.00	4,923,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	4,923,800.00	4,923,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	4,923,800.00	4,923,800.00

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Баянхонгор сумын 5 дугаар цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг төсвийн захирагч Б.Ишмаад танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд хөрөнгийн ангиллыг зөв бүртгэх, нэг удаагийн шинжтэй зардлыг бараа материалд бүртгэхгүй байх, шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлж байх, үндсэн хөрөнгийн ашиглагдах жилийг зөв тайлагнах зэрэг зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 23-ний өдрөөс 2020 оны 02 дугаар сарын 24-ны хооронд гүйцэтгэж, 2020 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор сумын 5 дугаар цэцэрлэг 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2021.01.22-ний өдөр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Тус байгууллага “Бага насны хүүхдийг эрүүл биетэй саруул ухаантай сайн хүн болж төлөвшихөд туслан хамтдаа хөгжих” эрхэм зорилго тавьж ажилласан байна.

Тайлант хугацаанд тус байгууллага дараах зорилт дэвшүүлэн ажиллажээ. Үүнд:

1. 2020-2021 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролын тойргийн хамран сургалтыг 93 хувьд хүргэнэ.
2. Эрүүл зан үйлийг төлөвшүүлж хүүхэд бүрийг өөрийгөө болон эрүүл мэндээ хамгаалах энгийн дадалд сургана.
3. Хүүхдийг багаас нь эх хэлээрээ зөв ярьж хэвших өөрийгөө илэрхийлэх, өөртөө итгэлтэй зөв хүүхэд төлөвшихөд дэмжлэг үзүүлнэ.

4. Улирал бүр “Сайн үйл ажиллагаа” аян зохион байгуулж хүүхэд бүрийг тоглонгоо суралцах арга зүй шийдлийг олж багшийн хөгжлийг дэмжин туршлагыг түгээн дэлгэрүүлж сайн багшийн хүрээг нэмэгдүүлнэ.
5. Багш, хүүхэд, байгууллагын ажлыг үнэлэх үнэлгээний аргачлал боловсруулан хэрэгжүүлнэ.
6. Цэцэрлэгийн хоол хүнсний хангамж үйлчилгээг стандарт шаардлага горимын дагуу гүйцэтгэж, аюулгүй байдлыг хангахад нэгж байгууллага, холбогдох албан тушаалтны үүрэг хариуцлагыг өндөржүүлнэ.
7. Насан туршийн боловсролын чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, иргэдийн амьдрах ухааны боловсролыг дээшлүүлэх эцэг эхийн сургалтыг эрчимжүүлнэ.
8. Хүүхэд бүрийн хөгжлийн онцлогийг илрүүлж IQ, болон 100 буудалт даам, бүжиг хөгжим дүрслэн урлахуйн дугуйлан ажиллуулж хүүхдийн хөгжлийг дэмжинэ.
9. Багш ажилтны ёс зүйн хэм хэмжээг сахин, хамт олны эв нэгдлийг бэхжүүлэн ажиллана.

Байгууллагын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Зөрчлийн тухай хууль
- Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
- Гамшгаас хамгаалах тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хуулиудад нэмэлт өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Баянхонгор сумын 5 дугаар цэцэрлэг нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон аудитор хийж гүйцэтгэлээ.

Баянхонгор сумын 5 дугаар цэцэрлэг нь “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн Acolous санхүүгийн программ хангамж ашигладаг байна.

Тайлант онд тус байгууллагад хяналт байгууллагуудаас шалгалт хийгдээгүй байна.

Баянхонгор сумын 5 дугаар цэцэрлэгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг үр дүнгийн тайлангийн зардлын 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны 03 дугаар улирлын санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас 2 хувиар буюу 8718.5 мянган төгрөгөөр тооцсон бол гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлын 2 хувиар буюу 12564.6 мянган төгрөгөөр тооцсон бөгөөд төлөвлөлтийн үе шатанд тооцсон материаллаг байдлын түвшнээс 3846.1 мянган төгрөгөөр их байгаа нь 4 дүгээр улиралд зардал нэмэгдсэнтэй холбоотой байна.

Аудитыг гүйцэтгэх явцад шинж чанарын болон орчин нөхцлийн хувьд материаллаг байдал илэрсэнгүй.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Баянхонгор сумын 5 дугаар цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 1319104.2 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 521719.2 мянган төгрөгөөр буюу 65.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

(мян.төг)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	63,620.4	46,895.0	(16,725.4)
Авлага	2,359.5	-	(2,359.5)
Бараа материал	61,260.9	46,895.0	(14,365.9)
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	733,764.6	1,272,209.2	538,444.6
Үндсэн хөрөнгө	883,906.7	1,474,053.1	590,146.5
Хуримтлагдсан элэгдэл	(150,142.0)	(201,843.9)	(51,701.9)
Нийт хөрөнгө	797,385.1	1,319,104.2	521,719.2
Өр төлбөр	-	20.5	20.5
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	797,385.1	1,319,083.7	521,698.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	797,385.1	1,319,104.2	521,719.2

Эх сурвалж: Байгууллагын 2020 оны санхүүгийн тайлан

Тус байгууллагын төрийн сан банкны 100032015205, 100032015412 харилцах данс оны эцэст үлдэгдэлгүй байна.

Оны эхэнд "Би Би Ди" ХХК-аас 2359.5 мянган төгрөгийн гадна гэрэлтүүлэг хийх ажлын авлагатай байсныг бүрэн барагдуулж, ажилтан Ш.Ганболдын цалинг нийгмийн

даатгалд мэдээлэхдээ кодыг зөрүүтэй оруулснаас оны эцэст 20.5 мянган төгрөгийн НДШ-ийг өглөгтэй гарчээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 46895.0 мянган төгрөг болж өмнөх оноос 14365.9 мянган төгрөгөөр буурсан нь байгууллагын даргын 2020.06.15-ний өдрийн А/34 дүгээр тушаалаар тусгай зориулалтын материалаас 16388.4 мянга, аж ахуйн материалаас 2934.3 мянга, бусад бараа материалын данснаас 118.2 мянга, нийт 20511.9 мянган төгрөгийн бараа материалыг акталж устгасантай холбоотой байна. Тайлант хугацаанд аймгийн Боловсрол, соёл урлагийн газраас 140.0 мянган төгрөгийн зайнаас халуун хэмжигч өгснийг үнэ төлбөргүй орлогоор бүртгэж авчээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оны эцэст 797385.1 мянган байсан ба тайлант онд төсвийн хөрөнгөөр 44714.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, цэцэрлэгийн хүүхдүүдийн эцэг эхчүүдээс 3499.9 мянган төгрөгийн 2 ширхэг автомат угаалгын машин, аймгийн Боловсрол, соёл урлагийн газраас 5248.5 мянган төгрөгийн 3 ширхэг зөөврийн компьютер, Нэгдсэн үндэсний байгууллагын Хүүхдийн сангаас 9916.0 мянган төгрөгийн гал тогооны тоног төхөөрөмж үнэ төлбөргүй ирсэн байна.

Нэгдсэн үндэсний байгууллагын Хүүхдийн сангийн санхүүжилтээр 454512.6 мянган төгрөгийн цэцэрлэгийн барилгын засварын ажлыг "МВС" ХХК, 47254.9 мянган төгрөгийн цэцэрлэгийн ариун цэврийн ерөөнүүдийн засварын ажлыг "Тэнгэрийн уул" ХХК гэрээ байгуулан гүйцэтгэж, барилгын их засварын ажлын 501767.5 мянган төгрөгийг санхүүгийн тайланд бүрэн тусгасан байна.

Байгууллагын 2020 оны төсөвт урсгал зардалд анх 25000.0 мянган төгрөг баталж, сантехникийн их засварыг хийхээр төлөвлөж, "МВС" ХХК нэмэлт гэрээ байгуулж хийж гүйцэтгэсэн бөгөөд барилгын шалыг паркетлах ажлыг аймгийн БОАЖГ-ын "Байгаль хамгаалах сан"-ийн санхүүжилтээс 25000.0 мянган төгрөгөөр хийж гүйцэтгэн бүртгэлд тусгасан байна.

Тайлант онд үндсэн хөрөнгө акталж устгаагүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүн 521698.6 мянган төгрөгөөр нэмэгдэж 1319083.7 мянган төгрөг болсон байна.

Баянхонгор сумын 5 дугаар цэцэрлэгийн тусгай зориулалтын шилжүүлэг өмнөх оноос 69299.2 мянган төгрөгөөр буюу 16.0 хувиар, орон нутгийн төсвөөс олгох тогтмол зардлын санхүүжилт 4004.2 мянган төгрөг буюу 4.3 хувиар өссөн байна.

Нийт зардал өмнөх онд 525022.9 мянган төгрөг байсан бол тайлант оны зардал өмнөх оноос 67619.8 мянган төгрөгөөр буюу 12.9 хувиар өсөж, 592642.8 мянган төгрөг гарсан нь өмнөх оны үзүүлэлтээс бараа үйлчилгээний зардлыг нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүнд өөрчлөлт ороогүй байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 /71801/ хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр тусгай зориулалтын шилжүүлгээр 501321.1 мянга, орон нутгийн төсвөөс 97030.3 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр батлагдсан санхүүжилтийг бүрэн авч, байгууллагын урсгал үйл ажиллагаанд 592642.8 мянган төгрөгийг зарцуулан, оны эцэст 5708.6 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Арга хэмжээ	Зардлын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
80109	ТЗШ-ийн байгууллагын тогтмол зардал	97,030,300.00	96,356,655.00	673,645.00
210301	Гэрэл, цахилгаан	7,698,500.00	7,311,169.00	387,331.00
210302	Түлш, халаалт	74,749,800.00	74,852,100.00	-102,300.00
210303	Цэвэр, бохир ус	13,582,000.00	13,193,386.00	388,614.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00	0
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	195,800.00	195,800.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	195,800.00	195,800.00	0
81807	Цэцэрлэгийн хүүхдийн хоол	36,038,000.00	35,102,850.00	935,150.00
210502	Хоол, хүнс	36,038,000.00	35,102,850.00	935,150.00
81834	Боловсролын стандарт, сургалтын	434,674,500.00	431,804,325.00	2,284,275.00
210101	Үндсэн цалин	273,043,200.00	272,377,807.00	665,393.00
210102	Нэмэгдэл	54,469,600.00	54,034,318.00	435,282.00
210105	Гэрээт ажлын цалин	1064900	0	1064900
	Нийгмийн даатгалын шимтгэл	41,190,000.00	41,189,100.00	
210401	Бичиг хэрэг	176,200.00	176,200.00	0
210403	Шуудан, холбоо, интернэт	1,450,400.00	1,450,400.00	0
210404	Ном, хэвлэл	97,900.00	97,900.00	0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх,	2,005,300.00	2,005,300.00	0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах зардал	4,591,400.00	4,591,400.00	0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,197,700.00	5,197,700.00	0
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,585,000.00	1,000,000.00	0
210604	Урсгал засвар	26,300,200.00	26,300,200.00	0
210702	Дотоод албан томилолт	182,700.00	64,000.00	118,700.00
210801	Бусад нийтлэг АҮТХураамж	743,800.00	743,800.00	0
210802	Аудит бат, зэрэглэл тогтоох	300,000.00	300,000.00	0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,000,000.00	8,000,000.00	0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага х	14,276,200.00	14,276,200.00	0
81835	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	30,412,800.00	29,183,191.00	1,229,609.00
210104	Урамшуулал	24,633,600.00	23,403,991.00	1,229,609.00
	Нийгмийн даатгалын шимтгэл	3,079,200.00	3,079,200.00	
210402	Тээвэр, шатахуун	1,400,000.00	1,400,000.00	0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон	1,000,000.00	1,000,000.00	0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх,	300,000.00	300,000.00	0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн Боловсрол, соёл урлагийн газраас хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжид 4923.8 мянган төгрөгийн санхүүжилт олгосныг бүлгийн багш Ч.Ганцэцэгт олгосон байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст оруулбал зохих 151 мэдээллээс 145 мэдээллийг хугацаанд нь оруулж, 163224.6 мянган төгрөгийн 6 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Хүснэгт 2. Шилэн дансанд байршуулсан мэдээлэл

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон
1	Бүтэн жил	11	11	10	1
2	Хагас жил	4	4	4	
3	Улирал бүр	1	4	4	
4	Сар бүр	3	36	35	1
5	Тухай бүр	8	96	92	4
	Нийт	27	151	145	6

Эх сурвалж: Баянхонгор сумын 5 дугаар цэцэрлэгийн шилэн данс

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитыг ахлах аудитор М.Алтантуяа хийж гүйцэтгэн зөвлөмж өгөөгүй бөгөөд аудитаар 2 зөрчилд 4926.5 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосныг бүрэн барагдуулсан байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар илэрсэн 12561.3 мянган төгрөгийн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар шийдвэрлэв.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт тайлагналын алдаатай холбоотой 195.8 мянган төгрөгийн дараах залруулгыг төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Тайлант онд нэг удаагийн тэтгэмж урамшууллын 213209 зардалд батлагдаж олгосон 195.8 мянган төгрөгийн зардлыг төсвийн гүйцэтгэлийн тайланд бусад тэтгэмж урамшууллын 213204 зардлаар тайлагнасан байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн гүйцэтгэлийн тайланд ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшууллын зардлыг 195.8 мянган төгрөгөөр бууруулж, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг нэмэгдүүлж залруулав.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 12497.5 мянган төгрөгийн 8 залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 2700.8 мянган төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 3014.5 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 6782.2 мянган төгрөгийн 4 алдаанд зөвлөмж хүргүүлэв. Үүнд:

1. "МТД" ХХК-ийн "Номгон" телевизийн захирал Д.Амгаланбаяртай 2020.12.17-ний өдрийн 04 тоот хамтран ажиллах 1650.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж, 2020.12.18-ний

өдөр 1650.0 мянган төгрөгийг шилжүүлж, 150.0 мянган төгрөгөөр өөрийн байгууллагын талаар нэвтрүүлэг бэлтгэж, 800.0 мянган төгрөгийг дууны шүлэг ая бичлэгийн үнэ, 700.0 мянган төгрөгийг клип хийлгэхэд гаргаж төсвийн хөрөнгийг үрэлгэн зарцуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох буруутай албан тушаалтнаар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

2. Цэцэрлэгийн эрхлэгч 2020.01.22-ний өдрийн А/07 дугаар тушаал гаргаж, илүү цагийн нэмэгдэл авдаггүй ажилтнууддаа өдөрт 5000 төгрөгийн хоолны мөнгө олгох тушаал гаргахдаа өөртөө олгохоор тушаал гаргаж, дарга 558.0 мянган төгрөгийн хоолны мөнгө авсан, нягтлан бодогч 558.0 мянга, нийт 1116.0 мянган төгрөгийн хоол унааны мөнгө авсан байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид өдрийн хоол унааны мөнгийг олгож байгааг зогсоож, төсвийн захирагч, нягтлан бодогч нарт олгосон хоол, унааны мөнгийг нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

Нягтлан бодогч А.Саранцэцэг өөрийн ээлжийн амралтын нөхөн олговрыг зөрүүтэй бодсоноос 84.8 мянган төгрөгийг илүү тооцож олгосон байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодогч А.Саранцэцэгээр төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

3. Баянхонгор сумын 5 дугаар цэцэрлэгийн даргаар ажиллаж байсан Б.Ишмааг Баянхонгор аймгийн Засаг дарга Г.Батжаргал 2018.11.22-ний өдрийн Б/774 дүгээр захирамж гарган ажлаас чөлөөлсөнд иргэн Б.Ишмаа хуулийн байгууллагад хандаж Баянхонгор аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 04 дүгээр сарын 01-ны өдрийн 111/ШШ2019/0006 тоот шийдвэрээр 2018.11.22-2019.04.01-ний өдөр хүртэлх 4 сар 6 хоногийн олговор 3.014.476 төгрөгийг олгохоор тогтоосныг 2020 оны 04 дүгээр сарын 29-ны өдөр тус байгууллагын 2020 оны цалингийн зардлаас олгосон байна.

Шийдвэрлэсэн нь: Буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх албан шаардлагыг аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанд хүргүүлэв.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 6782.2 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Цаг хугацааны хувьд богино, нарийвчилсан горим сорилыг гүйцэтгэж амжаагүй тул тайлагналын дараах үе шатанд цалин хөлстэй холбоотой асуудлыг тодруулан шалгах шаардлагатай байна.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. БАЛАНСЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

1.1. **Илрүүлэлт:** Бараа материалд 2186.3 мянган төгрөгийн 80, үндсэн хөрөнгөд 6380.7 мянган төгрөгийн 200 ширхэг гудас бүртгэлтэй, үндсэн хөрөнгөд проектор, шат, ус ваань, дохиолол зэрэг үндсэн хөрөнгийн шинжгүй хөрөнгө бүртгэсэн, хөрөнгийн нэрийг алдаатай бүртгэсэн байна.

1.2. **Эрсдэл:** Хөрөнгийг буруу ангилж бүртгэх.

1.3. **Өгсөн зөвлөмж:** Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн дансны зааварт заасны дагуу хөрөнгийг зөв ангилж бүртгэх.

1.4. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Хүлээн зөвшөөрч байна.

2. ТӨСВИЙН ӨМНӨ ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ

2.1. **Илрүүлэлт:** Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст оруулбал зохих 151 мэдээллээс 145 мэдээллийг хугацаанд нь оруулж, 163224.6 мянган төгрөгийн 6 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

2.2. **Эрсдэл:** Шилэн дансны тухай хуулийг мөрдөж, мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлээгүй байх.

2.3. **Өгсөн зөвлөмж:** Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг биелүүлж, хугацаанд нь мэдээллийг цахим хуудаст мэдээлж байх

2.4. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Хүлээн зөвшөөрч байна.

3. ЗАРДЛЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

3.1. **Илрүүлэлт:** Үндсэн хөрөнгөд ашиглагдах жилийг 1, -1 жилээр бүртгэсэн 7 нэр төрлийн 6782.2 мянган төгрөг бүртгэлтэй байна.

3.2. **Эрсдэл:** Үндсэн хөрөнгийн ашиглагдах жилийг буруу тайлагнах, үндсэн хөрөнгөд элэгдэл тооцохгүй байх.

3.3. **Өгсөн зөвлөмж:** Үндсэн хөрөнгийн ашиглагдах жилийг зөв бүртгэж, тайлант жилийн элэгдлийн зардлыг зөв илэрхийлж байх

3.4. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Хүлээн зөвшөөрч байна.

4. БАЛАНСЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

4.1. **Илрүүлэлт:** Самбарын зураг, төрийн мэдээлэл, код тэглэх зэрэг шууд зардлаар бүртгэх зардлыг бараа материалд орлогоор бүртгэсэн, харилцагчийн нэрийг санхүүгийн программд оруулдаггүй 5-р цэцэрлэг нэрээр бүртгэсэн байна.

4.2. **Эрсдэл:** Бараа материалын шинж чанаргүй хөрөнгийг бүртгэх, бэлтгэн нийлүүлэгчийн нэрийг санхүүгийн программд буруу оруулах

4.3. **Өгсөн зөвлөмж:** Бараа материалд хөрөнгийн шинж чанаргүй нэг удаагийн зардлыг бэлтгэн нийлүүлэгч байгууллагын хоорондын дансаар дамжуулан шууд зардлаар бүртгэх.

4.4. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Хүлээн зөвшөөрч байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг холбогдох нотлох баримтын хамт төрийн аудитын байгууллагад 2021 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

Бэлтгэсэн:

АХЛАХ АУДИТОР

Б.ДОЛЖМАА

Огноо: 2021.02.25

Анхан шатанд хянасан:

ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АУДИТЫН
МЕНЕЖЕР

А.ЦЭЭНЯМ

Огноо: 2021.02.25

Хоёр дахь шатанд хянасан:

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ

Огноо: 2021.02.25

5. Хавсралт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Баянхонгор сумын 5 дугаар цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021.02.25			БНА-2021/15/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Баянхонгор сумын 5 дугаар цэцэрлэг		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
A	1	2	3	4	5
1	"МТД" ХХК-ийн "Номгон" телевизийн захирал Д.Амгаланбаяртай 2020.12.17-ний өдрийн 04 тоот хамтран ажиллах 1650.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж, 2020.12.18-ний өдөр 1650.0 мянган төгрөгийг шилжүүлж, 150.0 мянган төгрөгөөр өөрийн байгууллагын талаар нэвтрүүлэг бэлтгэж, 800.0 мянган төгрөгийг дууны шүлэг ая бичлэгийн үнэ, 700.0 мянган төгрөгийг клип хийлгэхэд гаргаж төсвийн хөрөнгийг үрэлгэн зарцуулсан.	1500.0	Төлбөрийн акт тогтоох	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Э.Оюунтуяа, А.Саранцэцэг
2	Цэцэрлэгийн эрхлэгч 2020.01.22-ний өдрийн А/07 дугаар тушаал гаргаж, илүү цагийн нэмэгдэл авдаггүй ажилтнууддаа өдөрт 5000 төгрөгийн хоолны мөнгө олгох тушаал гаргахдаа өөртөө олгохоор тушаал гаргаж, дарга 558.0 мянган төгрөгийн хоолны мөнгө авсан, нягтлан бодогч 558.0 мянга, нийт 1116.0 мянган төгрөгийн хоол унааны мөнгө авсан.	1116.0	Төлбөрийн акт тогтоох	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Э.Оюунтуяа, А.Саранцэцэг
3	Нягтлан бодогч А.Саранцэцэг өөрийн ээлжийн амралтын нөхөн олговрыг зөрүүтэй бодсоноос 84.8 мянган төгрөгийг илүү тооцож олгосон байна.	84.8	Төлбөрийн акт тогтоох	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Э.Оюунтуяа, А.Саранцэцэг
4	Баянхонгор сумын 5 дугаар цэцэрлэгийн даргаар ажиллаж байсан Б.Ишмааг Баянхонгор аймгийн Засаг дарга Г.Батжаргал 2018.11.22-ний өдрийн Б/774 дүгээр захирамж гарган ажлаас чөлөөлсөнд иргэн Б.Ишмаа хуулийн байгууллагад хандаж Баянхонгор аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 04 дүгээр сарын 01-ны өдрийн 111/ШШ2019/0006 тоот шийдвэрээр	3014.5	Албан шаардлага өгөх	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Э.Оюунтуяа, А.Саранцэцэг

**Баянхонгор сумын 5 дугаар Цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

	2018.11.22-2019.04.01-ний өдөр хүртэлх 4 сар 6 хоногийн олговор 3.014.476 төгрөгийг олгохоор тогтоосныг 2020 оны 04 дүгээр сарын 29-ны өдөр тус байгууллагын 2020 оны цалингийн зардлаас олгосон.				
5	Самбарын зураг, төрийн мэдээлэл, код тэглэх зэрэг шууд зардлаар бүртгэх зардлыг бараа материалд орлогоор бүртгэсэн, харилцагчийн нэрийг санхүүгийн программд оруулдаггүй 5-р цэцэрлэг нэрээр бүртгэдэг.	0	Зөвлөмж өгөх	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Э.Оюунтуяа, А.Саранцэцэг
6	Үндсэн хөрөнгөд ашиглагдах жилийг 1, -1 жилээр бүртгэсэн 7 нэр төрлийн 6782.2 мянган төгрөг бүртгэлтэй байна.	6782.2	Зөвлөмж өгөх	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Э.Оюунтуяа, А.Саранцэцэг
7	Бараа материалд 2186.3 мянган төгрөгийн 80, үндсэн хөрөнгөд 6380.7 мянган төгрөгийн 200 ширхэг гудас бүртгэлтэй, үндсэн хөрөнгөд проектор, шат, ус ваань, дохиолол зэрэг үндсэн хөрөнгийн шинжгүй хөрөнгө бүртгэсэн, хөрөнгийн нэрийг алдаатай бүртгэсэн.	0	Зөвлөмж өгөх	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Э.Оюунтуяа, А.Саранцэцэг
8	Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст оруулбал зохих 151 мэдээллээс 145 мэдээллийг хугацаанд нь оруулж, 163224.6 мянган төгрөгийн 6 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.	0	Зөвлөмж өгөх	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Э.Оюунтуяа, А.Саранцэцэг
9	Тайлант онд нэг удаагийн тэтгэмж урамшууллын 213209 зардалд батлагдаж олгосон 195.8 мянган төгрөгийн зардлыг төсвийн гүйцэтгэлийн тайланд бусад тэтгэмж урамшууллын 213204 зардлаар тайлагнасан.	195.8	Зөвлөмж өгөх	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Э.Оюунтуяа, А.Саранцэцэг
ДҮН		12693.3			

---oOo---